

I-III/2021


Тархаасан: 2021 оны 04 дүгээр сарын 14



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 43.9 хувиар өслөө

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 4.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1421.8 (43.9%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1121.5 (53.7%) тэрбум төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 261.8 (35.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна. Мөн цахилгаан хий, уур, агааржуулалтын салбарын үйлдвэрлэл 34.0 (9.1%) тэрбум төгрөгөөр, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын үйлдвэрлэл 4.4 (13.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 1. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл, салбараар, сараар, тэрбум төгрөг



Нийт үйлдвэрлэл 2021 оны 3 дугаар сард 1.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 192.9 (13.3%) тэрбум төгрөгөөр өсжээ. Үүнд уул уурхай, олборлох салбарын нийт үйлдвэрлэл 120.8 (12.0%) тэрбум төгрөг, боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 81.0 (27.8%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны 3 дугаар сард урьдчилсан гүйцэтгэлээр 1.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 460.5 (69.1%) тэрбум төгрөгөөр өсөхөд нүүрс олборлолт 153.4 (72.0%) тэрбум төгрөгөөр, газрын тос олборлолт 77.8 (31.7 дахин) тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт 233.9 (55.0%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 2021 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр алт, зэсийн баяжмал, хүрэн нүүрс, төмрийн хүдэр, чулуун нүүрс, газрын тос болон хайлуур жоншны олборлолт өмнөх оны мөн үеэс 10.6 хувиас 4.3 дахин, боловсруулах аж үйлдвэрийн салбарт гурил, цэвэр спирт, шингэн сүү, согтууруулах ундаа, нүүрсэн шахмал түлш, амны хаалт, малын мах, баяжуулсан нүүрс болон цемент зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 4.4 хувиас 4.1 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2020		2021*		2021* I-III %
		III	I-III	III	I-III	2020 I-III
Уул уурхай, олборлох аж үйлдвэр						
Чулуун нүүрс	мян.т	1 922.1	6 140.3	2 890.1	10 182.1	165.8
Хүрэн нүүрс	мян.т	544.2	1 957.0	667.2	2 192.4	112.0
Газрын тос	мян.баррел	40.2	461.6	511.2	1 509.2	3.3 ¹
Зэсийн баяжмал, металл агуулгаараа	мян.т	105.1	308.0	130.2	342.8	111.3
Алт	кг	941.7	2 411.5	1 175.1	2 667.0	110.6
Төмрийн хүдэр	мян.т	383.2	895.7	912.6	1 418.2	158.3
Хайлуур жонш	мян.т	5.4	7.8	7.4	33.5	4.3 ¹
Боловсруулах аж үйлдвэр						
Малын мах	т	332.1	2 368.9	2 354.8	5 631.4	2.4 ¹
Шингэн сүү	мян.л	3 488.0	10 481.3	3 971.3	13 030.7	124.3
Гурил	т	16 466.6	56 352.7	15 578.7	58 853.0	104.4
Цэвэр спирт	мян.л	862.1	2 751.5	1 227.9	3 209.6	116.7
Согтууруулах ундаа	мян.л	9 663.2	24 999.7	11 950.7	31 560.3	126.2
Ус, ундаа, жүүс	мян.л	37 921.4	93 324.2	18 237.3	67 086.4	71.9
Янжуур тамхи	мян.блок	-	-	247.5	799.6	-
Амны хаалт	мян.ш	1 228.7	2 076.6	300.5	4 570.8	2.2 ¹
Эмчилгээ, урьдчилан сэргийлэх зориулалттай бусад төрлийн эм, ариутгалын бэлдмэл	мян.л	83.6	157.9	22.9	83.2	52.7
Ноолууран сүлжмэл эдлэл	мян.ш	59.6	283.5	86.2	148.1	52.2
Самнасан ноолуур	т	10.2	74.7	42.4	136.0	182.1
Баяжуулсан нүүрс	т	171.8	529.6	533.3	1 406.6	2.7 ¹
Нүүрсэн шахмал түлш	мян.т	32.1	173.2	85.8	335.9	194.0
Цемент	мян.т	34.3	34.3	81.8	141.3	4.1 ¹
Шохой	т	5 698.9	18 750.2	4 045.1	15 631.3	83.4
Катодын зэс, 99%	т	727.0	2 448.1	845.7	2 424.9	99.1
Металл бэлдэц	т	41.7	4 658.5	3 541.8	3 591.0	77.1

¹дахин их

Харин боловсруулах аж үйлдвэрийн салбарт катодын зэс, металл бэлдэц, шохой, ус, ундаа, жүүс, гар ариутгагч, ноолууран сүлжмэл эдлэл зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.9-47.8 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2021 оны эхний улирлын байдлаар урьдчилсан гүйцэтгэлээр 6.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.0 (94.7%) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулалт 2.6 (2.4 дахин) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Хүснэгт 2. Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн, салбараар

Салбар	2020		2021*			2021* I-III
	III	I-III	III	I-III	гадаадад	2020 I-III
	тэрбум төгрөг					хувь
Нийт дүн	1 005.5	3 183.4	2 287.6	6 198.9	1 267.3	194.7
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	634.5	1 820.9	1 607.6	4 433.3	1 100.5	2.4 ¹
Боловсруулах аж үйлдвэр	243.4	953.9	537.0	1 318.9	166.8	138.3
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	116.8	375.9	128.8	408.0	-	108.5
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	10.8	32.7	14.2	38.7	-	118.1

¹дахин их

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 2.6 (2.4 дахин) тэрбум төгрөгөөр өсөхөд металлын хүдэр олборлолтын салбарын борлуулалт 1.6 (2.3 дахин) их наяд төгрөгөөр, нүүрс олборлолтын салбарын борлуулалт 858.3 (2.9 дахин) тэрбум төгрөгөөр, газрын тос олборлолтын салбарын борлуулалт 162.6 (4.3 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлөв.

Зураг 2. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн, салбараар, сараар, тэрбум төгрөг



Нийт борлуулсан бүтээгдэхүүний 1.3 их наяд төгрөг буюу 20.4 хувийг гадаад зах зээлд борлуулжээ. Гадаад зах зээлд борлуулсан нийт бүтээгдэхүүний 1.1 их наяд төгрөг буюу 86.8 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн эзэлж байна. Гадаад зах зээлд борлуулсан уул уурхайн бүтээгдэхүүний 58.7 хувийг металлын хүдэр олборлолтын

салбарын бүтээгдэхүүн, 33.1 хувийг нүүрс олборлолтын салбарын бүтээгдэхүүн, 6.7 хувийг газрын тос олборлолтын салбарын бүтээгдэхүүн, 1.5 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбарын бүтээгдэхүүн эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс (үлирлын нөлөөллийг арилгасан тооцоо) 2021 оны 3 дугаар сард 165.3 (2015=100) болж, өмнөх оны мөн үеэс 78.3 хувиар, өмнөх оны эцсээс 16.7 хувиар өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал: НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд нийцүүлэн боловсруулсан үндэсний ангилал юм.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн (биет хэмжээний) индекс: Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, Ласпейрсийн биет хэмжээний индексийн томъёог ашиглан тооцно.

Тооцох аргачлал:

Ласпейрсийн биет хэмжээний индексийн томъёо:

$$I_{LQ} = \frac{\sum(Q_t \cdot P_0)}{\sum(Q_0 \cdot P_0)} \cdot 100 = \sum\left(\frac{Q_t}{Q_0}\right) \cdot W_0 \cdot 100$$

Qt- Бүтээгдэхүүний тайлант үеийн биет хэмжээ

Q0- Бүтээгдэхүүний суурь үеийн биет хэмжээ

P0- Бүтээгдэхүүний суурь үеийн үнэ

W0- Жин

Тайлбар: ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: ҮСХ, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархах хуваарь: 2021 оны 5 дугаар сарын 17



*Эдийн засгийн статистикийн
газрын дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414*

*Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Б.Уянгаа
статистикч Б.Энхболд
Утас : (976-51)-261563*